



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/318

Есөнбулаг сум

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 11.4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай" жагсаалт, Есөнбулаг сумын "Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны ялагчаар тодорсон Юнайтэдбест ойл ХХК-ний эзэмших газрын зориулалт, хэмжээг 1 дүгээр хавсралтаар, байршлыг 2 дугаар хавсралтаар баталж, 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн "Юнайтэдбест ойл ХХК"-ний мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч (А.Оюун-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ




Аймгийн Засаг даргын 04-ны өдрийн дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрынх эмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	Юнайтэдбест ойл ХХК	5892716	Эзэмших	4297949	3457	Баянхайрх ан баг	Үйлчилгээтэй орон сууц (2207)	15

"ЮНАЙТЭДБЕСТ ОЙЛ" (5892716) - ИЙН ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800
Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баанцайрхан баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)



Огноо: 2025-06-29

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5138741.940	288145.830	40.79	1-2
2	5138718.110	288112.720	84.71	2-3
3	5138786.803	288083.153	40.80	3-4
4	5138810.675	288098.236	84.76	4-5
5	5138741.940	288145.830	0.00	5-1

Талбайн хэмжээ: 3457.0 квадрат метр